



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

167 /167/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.10.29

## "ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛ"-ИЙН АНХДУГААР ХУРАЛДААН БОЛЛОО

Түүхэнд энэ өдөр



1982 он:  
БНМАУ-ын Батлан хамгаалах яамны сайдаар хурандаа генерал Ж.Ёндон томилогдов.

1989 он.  
БНМАУ-ын Батлан хамаалах яамны сайдаар Л.Моломжамц томилогдов.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 5	☁️ -13

#### ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 23

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалахын сайдад дэмжлэг үзүүлэх, цэрэг-иргэний харилцааг бэхжүүлэх, цаашид хийж хэрэгжүүлэх арга

замыг тодорхойлох зорилго бүхий Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-ийн анхдугаар хуралдаан боллоо. Энэхүү хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож, шинээр томилогдсон "Иргэний зөвлөл"-ийн гишүүдийг хүлээн авч уулзаж, албанд нь амжилт хүслээ.

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ-100

#### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЦАХИМ ХЭЛБЭРТ ШИЛЖЛЭЭ

Тус эмнэлгийн үйлчилгээг иргэд, цэргийн алба хаагчдад түргэн шуурхай, найдвартай хүргэх үүднээс цахим хэлбэрт шилжүүлжээ. Энэ тухай Цэргийн төв эмнэлгийн сүлжээний инженер, дэслэгч Д.Ганбилэг хэлэхдээ "Цахим хэлбэрт шилжүүлснээр иргэд өвчний түүх болон бусад шаардлагатай бичиг баримтуудаа цаасаар барьж явах шаардлагагүй болж байгаа юм. Тухайн үйлчлүүлэгчийн иргэний эмнэлэгтэй холбоотой бүх мэдээлэл нь нэгдсэн системийн дата баазад бүргэгдэнэ. Ингэснээр шинжилгээний хариугаа ч мөн цахим хэлбэрээр хүлээн авах боломжтой" гэсэн юм.

#### ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГА ЯВУУЛЖ ЭХЭЛЛЭЭ

Монгол Улсад "COVID-19"-ийн цар тахал дэгдсэнээс үүдэж Эрүүл мэндийн сайдын 2020 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн "Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах" албан даалгаврын дагуу Цэргийн төв эмнэлэг нь халдвар авсан иргэдэд тусламж үйлчилгээг өнөөдрийг хүртэл үзүүлж байна.

Хэдий тийм ч эмнэлгийн үндсэн үйл ажиллагаа болох хэвтэн эмчлүүлэх хэсэг, амбулаторийн үзлэг /поликлиник/ үйлчилгээг энэ сарын 25-ны өдрөөс эхлэн явуулж эхэллээ.



### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,850.0	2,853.0
EUR	3,312.0	3,322.0
CNY	445.0	446.50
RUB	40.60	41.50
JPY	25.05	25.25
KRW	2.39	2.41

### ЗУРХАЙ

2021.10.29 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 23/

НАМРЫН АДАГ ШАР НОХОЙ САР ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ЦАГААН НОХОЙ ӨДӨР

#### Үс ЗАСУУЛБАЛ:

Эд эдлэл идээ ундаа олдоно  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.32-17.39

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Хуран үйлдэхүй

Суудал:

Мод


Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үсэг зурхайд суралцах, бэрийн болон буяны үйл, дайсныг дарахад сайн. Зүүн нүд татвал үзэсгэлэн болох, баруун нүд татвал үйл өчүүхэн бүтэх, баруун чих хангинавал гоо болох, зүүн чих хангинавал сайн. Нохой уливал хааны хэрэг болох, хэрээ дуугарвал өөрийн цусыг үзэх, тагнай загатнавал гэрт үзэсгэлэн болох, бүх бие татвал эд алдах, хөлийн мах татвал сайн гэдэг.

### ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ

### ЦАХИМ УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Хуурай замын цэргийн командлалаас нэгтгэл, ангиудын шинэ дайчдын сургалтын төвүүдэд ажиллаж ахлагч нартай цахим уулзалт зохион байгууллаа.

Тус уулзалтыг Хуурай замын цэргийн командлалын ахлагч, тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр, Цэргийн сургалт, соёл хүмүүжлийн хэлтсийн сэтгэл зүйн хангалтын офицер, ахмад Ц.Ганбат, Захиргааны удирдлагын хэлтсийн хуулийн офицер, ахлах дэслэгч Д.Отгонгэрэл нар удирдан явууллаа. Цахим уулзалтын үеэр шинэ дайчидтай ажиллахдаа хууль эрх зүйн болон сургалт, цэргийн алба, ёс зүйн талаар анхаарах асуудлуудыг хэлэлцэж уулзалтын төгсгөлд тэргүүн ахлагч Д.Мөнхбаяр холбогдох үүрэг чиглэл өгөв.



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН 351,699 +1625	ЭДГЭРСЭН 531,617	НАС БАРСАН 1,599 +10
-----------------------------------	---------------------	-------------------------

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН 5986 +102	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 235	ЭДГЭРСЭН 5537
------------------------------	----------------------------	------------------

**КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД**

Тохиолдол Нийт: 245,275,484
Эдгэрсэн Нийт: 222,349,743
Нас барсан Нийт: 4,978,725

ЦАХИМ ШУУДАНД

# ЦЭРГИЙН ЧУУЛГЫНХАН САРЫН АЖЛАА ДҮГНЭЛЭЭ



ЦДБЭЧ-ын хамт олон 2021 оны I-X сард хийж гүйцэтгэсэн ажлаа дүгнэн хэлэлцэж, тайлангийн хурлаа зохион байгууллаа. Тайлант хугацаанд чуулгын хамт олон Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулсан цахим контентод оролцсоны зэрэгцээ Олон Улсын хээрийн сургуульд оролцож буй цэрэг дайчдад зориулсан тоглолт арга хэмжээ, нээлт, хаалтын ажиллагаа, 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор аж ахуй, тохижилт үйлчилгээний ажлуудыг шат дараатайгаар хийж гүйцэтгэсэн байна.

Мөн Төрийн албан хаагчийн ёс зүй, хууль

эрх зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр байгууллагын хэмжээнд хууль эрх зүйн сургалтыг зохион байгуулан сорил авч дүгнэн, нийгмийн хариуцлагын хүрээнд "Сэтгэлийн өглөг" аян, "Цусаа бэлэглэж, цохилох зүрх бүхнийг аваръя!" зэрэг аянууд, бие бүрэлдэхүүний эрүүл мэндийн багц үзлэг шинжилгээнд идэвхтэй хамрагдсан сарууд байлаа. Сарын ажлаа дүгнэж хэлэлцсэний дараагаар "Цэргийн тангараг" давтах хүндэтгэлийн ажиллагааг зохион байгуулж, "Сарын ажлын дүн"-г чуулгын даргын тушаалаар баталгаажууллаа.

## ЭХ ОРНЫ ХӨВГҮҮД СУРАЛЦАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний 311 дүгээр анги

2021 оны цэрэг татлагын хүрээнд цахим сүлжээгээр олон олон сайхан нийтлэлүүд, цэрэгт явахыг зорьсон залуусын тэмүүлэл, зорилго, тэнцэж чадалгүй нулимс дуслуулсан талаарх ярианууд, олны танил эрхмүүдийн үр хүүхдээ цэрэгт үдэж буй сэтгэгдэл гээд уншсан, сонссон мэдээллүүд маань цэргийн бидний сэтгэлийг машид ихээр өргөлөө гэж би харж байна. Эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхэд цэргийн бидэнд албаны итгэл үнэмшил зайлшгүй хэрэгтэй. Эх орноо нандигнаагүй, эрх чөлөөний үнэ цэнийг мэдрээгүй, цэргийн албаны сайханд дурлаагүй

хэн хүнтэй ажиллахад бэрхээс гадна хамт алба хааж байгаа бүрэлдэхүүний уур амьсгалыг эвдэж, харилцааны доголдол ч үүсгэдэг сөрөг талтай.

Гэтэл энэ жил тийм биш бололтой. Шинэхэн цэргүүдээ хүлээн авч бэлтгэлээ базааж байгаа офицер хөнгөхөн инээмсэглээд "Манай цэргүүд өөр байна аа. Эрч хүчтэй, сэргэлэн цовоо, албандаа хурдан дадах байх аа" гэхэд цэргийн дарга бүхний сэтгэл амрах шиг... Бид олны хүүхдэд алив чадахаа зааж, сургаж, нийгэмд олон хүнтэй харилцах харилцааны чадвар, цаг баримталж,

төлөвлөж сургах, багаар ажиллах чадвар, бие даан шийдвэр гаргах, аливааг бодож тунгаан дүгнэлт гаргах, өв тэгш бие бялдрын хөгжил олгох чадваруудыг эзэмшүүлэхийг зорьдог гадна бидний нэн тэргүүн зорилго бол "Цэрэг-эх оронч" сэтгэлгээтэй иргэн төлөвшүүлэхэд оршдог юм. Одоохондоо тэд маань баруун, зүүн 1, 2 гээд будилцааж байгаа ч сарын дараа цэгцэрчихнэ ээ. Жагсаалдаа хөлөө олчихсон, цэгц алхаатай байлдагчийн тэргүүн доош бөхийдөггүй. Генералын мөрдөс халаасалчхаад алхаж байгаа эдгээр хөвгүүдийн цог золбоо цэргийн дарга нарыг урамшуулж байдаг юм.

Ахмад Л.САРАНЗАЯА

ТАНЫ СОНОРТ

## НӨХӨН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХЫГ УРЬЖ БАЙНА

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн тэдгээрийн ар гэрийнхнийг "COVID 19" буюу коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор нөхөн дархлаажуулалтыг 2021 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 8-ны өдрийг хүртэл долоо хоногийн хугацаатай "Алдар" спорт хорооны байрлалд зохион байгуулна.

Н ө х ө н дархлаажуулалтад АНУ-ын "Файзар" вакцин ашиглах бөгөөд вакцинаа аваагүй болон I, II тундаа хамрагдсан Зэвсэгт хүчний офицер, ахлагч, ажилтан алба хаагч, ахмад дайчид, бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад настан, тэдгээрийн ар гэр, 12-оос дээш насны хүүхэд залуусыг хамруулна. Ингэхдээ Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/642 тушаалын дагуу

ВАКЦИНД ХАМРАГДСАН БАЙДАЛ	II ТҮНД ХАМРАГДАХ ХУГАЦАА	III ТҮНД ХАМРАГДАХ ХУГАЦАА
Ваццины I тунтай иргэд	21 ХОНОГИЙН ДАРАА II ТҮНД ХАМРАГДАХ	II ТҮНД ХАМРАГДААД 3 САРЫН ДАРАА III ТҮНД ХАМРАГДАХ
Ваццины II тунтай 18-аас дээш насны иргэд		II ТҮНД ХАМРАГДСАНААС ХОЙШ 3 САРЫН ДАРАА III ТҮНД ХАМРАГДАХ
Ваццины I тунд хамрагдаад II тунд хамрагдахгүй 3-аас дээш сар болсон 18-аас дээш насны иргэд	(КОВИД-19)-ЫН ЭСРЭГ ФАЙЗЕР-ВИОНТЕХ ҮЙЛДВЭРИЙН "КОМИРНЭТИ", СИНОФАРМ/ВВВР ҮЙЛДВЭРИЙН "СОРВ" ВАКЦИНААС СОНГОЛТ ХИЙЛГЭЖ, ШИНЭЭР I, II (G1 ХОНОГИЙН ДАРАА) ТҮНД ХАМРАГДАХ	
Ваццины I тунтай иргэд	ЭДГЭСНЭЭС 21 ХОНОГИЙН ДАРАА II ТҮНД (ВАКЦИНЫ СОНГОЛТОЙ) ХАМРАГДАХ	II ТҮНД ХАМРАГДААД 3 САРЫН ДАРАА III ТҮНД ХАМРАГДАХ
Ваццины II тунтай 18-аас дээш насны иргэд	ЭДГЭСНЭЭС 21 ХОНОГИЙН ДАРАА III ТҮНД ХАМРАГДАХ	

коронавирусийн тун хоорондын зайг мөрдөх юм. **ЗХХШ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС ХОЛБОО БАРИХ ДУГААР 70142024**

## УСНЫ ДАДЛАГА СУРГУУЛЬ ЯВУУЛАХ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ СҮҮЛИЙН ҮЕИЙН ЗАВЬ ХЭРЭГСЛЭЭР НӨХӨН ХАНГАГДЛАА

Зэвсэгт хүчний 234 дүгээр анги

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын харьяа ангиудын сургалтын материаллаг баазыг сайжруулах хамтын ажиллагааны хүрээнд Хуурай замын цэргийн командлалын инженерийн дарга, дэд хурандаа Г.Мөнхбат ОХУ-ын сүүлийн үеийн загвар хийцээр үйлдвэрлэгдсэн 8 хүний суудалтай 2 завь, 10 хүний суудалтай 1 завь, аврах хантааз 40 ширхэг, өндөр хүчин чадалтай гар радио станц 6 ширхгийг хүлээлгэн өглөө. Ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаяр ангийн сургалтын материаллаг баазыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажилласан Хуурай замын цэргийн командлалын удирдлага, хамт олон болон дэд хурандаа Г.Мөнхбатад баярлаж талархсанаа илэрхийлж ажлын амжилт хүслээ.

Дэслэгч Ч.ОЮУНЧИМЭГ



## СУРГАЛТАД ЯВУУЛЛАА

Зэвсэгт хүчний 120 дугаар анги

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн төвийн Хан-Уул дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хэлтсийн сэтгэл зүйч Р.Бадамцэцэг, хүүхдийн оролцоо хариуцсан мэргэжилтэн Б.Болор-Эрдэнэ нарыг урьж сургалт зохион байгуулав. "Гэр бүл ба

гэрлэлт", "Эхний мөчлөг ба хямрал", "Гэр бүл бол хүний үндсэн хэрэгцээг хангах орчин", "Бид хоёрын харилцаа", "Аливааг олж авах эрмэлзлийн хувьд", "Хайр-харилцаа" гэсэн сэдвүүдээр сургалтыг зохион явууллаа.

Сургалтад ангийн байнгын бие бүрэлдэхүүн идэвх санаачилгатай оролцлоо.

